

НОМЫН ДАЛАЙ

УЛАМЖЛАЛТ МОНГОЛ АНАГААХ
УХААНЫ ЗАРИМ НОМ СУДРЫН ТУХАЙ

3. Санждорж

Монголын анагаах ухаан өөрийн өвөрмөц онцлогийн дагуу Энэтхэг, Төвд хийгээд дорнодахины анагаах ухаантай нягт холбоотой хөгжиж байжээ. Эртний Энэтхэгийн анагаах ухааны «Найман гишүүнт зүрхэн хураангуй», «Сарангэрэлт» зэрэг хорь орчим зохиолыг ХҮИ зууны үед монгол хэлээр орчуулсан нь монгол оронд Энэтхэг, Төвдийн чиглэлтэй анагаах ухаан цаашид өргөжин хөгжихөд чухал түлхэц өгчээ.¹

Мөн XVШ зууны эхээр Төвд эмнэлгийн үндсэн сурах бичиг болох «Рашаан, зүрх найман гишүүнт нууц увидасын үндэс», «Лхантав» зэрэг олон арван зохиолуудыг монгол хэлээр орчуулж өөрсдийнхөө онол, эмчилгээний талаархи мэдлэгээ улам нарийвчлан баяжуулсан байна.² Монгол эмч нар Энэтхэг, Төвдийн анагаах ухааны ихэнх зохиол бүтээлүүдийг орчуулан шинжилж судлахын зэрэгцээ өөрийн орны ард түмний өвөрмөц ахуй амьдралд тохирсон уламжлалт эмийн эмчилгээ болон бариа засал, төөнөх, самнах, ханах, хатгах гэх мэт эмийн бус эмчилгээний олон аргыг багтаасан монгол анагаах ухааны сонирхолтой өдий төдий чухал бүтээлийг төвд хэлээр туурвиж хэвлүүлсэн нь дорно дахины анагаах ухаанд оруулсан томоохон хувь нэмэр болжээ. Энэ бүгдийг бүрэн төгс хамааруулан өгүүлэх боломжгүй нь мэдээж билээ. Иймээс энэ удаа зөвхөн XVI-XIX зууны үеийн монголын алдарт эмч нарын төвд хэлээр зохиосон ном, судраас тойм төдий товчхон өгүүлье.

1. Манай халхын эмч Лувсанданзанжанцан (1639 — 1704) нь XI машид гарсны шарагчин туулай жил Чингис хаан язгуурын нэгэн тайжийн хүү болон мэндэлжээ. Тэр багадаа цовоо сэргэлэн, хурц ухаантай хүүхэд байсан бөгөөд Содном гэдэг ламаар монгол, төвд бичиг заалгаж гарамгай сайн сурсан байна.

1659 онд Төвдийн Лхаст очиж Линдончойжи хэмээх эмчээр төвдийн анагаах ухааны олон ном, зохиол заалгаж бүрэн эзэмшсэн ба яруу найраг, гүн ухаан, зурхай зэрэг олон талын өндөр мэдлэгтэй болжээ. Лувсанданзанжанцан монгол нутагтаа буцаж ирээд төвд хэлээр дөрвөн боть ном зохиож Сайн ноёнхан аймагтаа модон бараар хэвлүүлсэн байна.

«Анагаах ухааны язгуур үндсийн тайлбар-Зажүдвийн далба» хэмээх бүтээл нь 55х9 см-ийн хэмжээтэй, нийт 41 хуудас модон барын хэвлэл ажээ. Уг бүтээлийн эхний хуудсанд зохиогчийн зургийг байрлуулсан нь Төвдийн анагаах ухааны гол гарын авлага болох энэ судрыг монгол нутагт засамжлан тайлбарлаж, онолын талаар баяжуулсан халх монголын эмчийн алдрыг мөнхжүүлснийг онцлон тэмдэглүүштэй.

«Өвчний ялгал-Наджи яв» хэмээх зохиолдоо 404 өвчнийг үндсэн 4 хэсэг болгон хувааж өвчнийг төрөл зүйлээр хэрхэн ялгах үндсэн арга, зарчмыг тодорхойлж, өвчин тус бүрийг дэс дараалан тоочиж бичсэн нь тухайн үеийн өвчин зүйн онолыг ихэд баяжуулсан байна.

«Хүйтнийг дарагч-Данба жижом» хэмээх зохиолдоо ялангуяа хүйтэн өвчнийг дарах найрлагыг чухалчлан заасан нь эрс тэс уур амьсгалтай монгол орныхоо өвөрмөц онцлогтой нягт уялдуулж чадсан нь бахархууштай,

«Хорин тавтын найрлагын аймаг-Нэрэн-аа-дэцан» хэмээх зохиолдоо үргэлж хэрэглэгддэг 25 найрлагатай эмүүдийг түүвэрлэн эмхэтгэсэн байна. Монгол анагаах ухааны нэрт төлөөлөгч эрдэмтэн, эмч Лувсан данзанжанцан 1704 онд эх нутагтаа таалал төгсжээ.

П. Монголын нэрт эрдэмтэн, эмч Ишбалжир (1704—1788) он ХП машинд гарсны хөх бичин жил Доржжанцангийн IV хүү болон төржээ. Тэр 4 настайгаасаа эхлэн төвд бичиг заалгаж улмаар Гүмбумд очиж анагаах ухаан, уран зохиол, үлгэр домог, гүн ухаан зэргийг сурч судалсан байна. Ишбалжирын зохиосон «Рашааны ундрал-Дүзи чүжү», «Рашааны цагаан шүүдэр Дүзи силгар», «Рашааны дусал-Дүзи тигва» «Рашааны хурим-Дүзи гаадан» хэмээх 4 дэвтэр энэ бүтээл нь монгол анагаах ухааны үндсэн онол, эмчилгээний баялаг туршлагыг багтаасан судалгааны онцгой чухал ач холбогдолтой бүтээлүүд юм. Тухайлбал: «Монгол хүний ёсоор тархи доргисныг засах арга», «Бэртэнг засах», «Үе мултарсныг засах», «Идээ ундаагаар анагаах»⁴ зэрэг эртний уламжлалт монгол эмнэлгийн эмчилгээний олон арга туршлагыг эмхэтгэн туурвисан байна. Ялангуяа «Тарваган тахлыг анагаах нь»⁵ гэсэн бүлэгт тарваган тахлыг үүсэх шалтгаан нөхцөл, шинж тэмдэг, засах арга, хор хөнөөл, урьдчилан сэргийлэх арга, халдварлах зам зэргийг маш тодорхой өгүүлжээ.

Жишээ нь: «Ичээндээ байгаа өвчтэй тарваганы мах идвээс тарваган тахлаар өвчилмой» гэж тодорхойлсон байна. Ишбалжираас өмнө тарваган тахлын тухай дурьдсан мэдээ баримт одоо хүртэл олдоогүй байна. Харин XIX зууны үед зохиосон монгол эмч Чоймпилын «Энэрэнгүй хураангуй-Жэдүйнин-ор» хэмээх эмийн сударт тарваган тахлын тухай товч дурьдсан байдаг. Мөн Ишбалжир «Эмт бодисыг таних болор толь-Ойнзин-шилгармэлон» хэмээх зохиолдоо нийт 800 гаруй эмийн зүйлийг чулуун эмийн аймаг, эрдэнийн эмийн аймаг, өвсөн эмийн аймаг гэх мэт 7 аймаг болгон хувааж эмийн ургамал тус бүрийн ургах газар, хэлбэр дүрс, амт чанар, чадлыг тодорхой бичсэн ажээ.

Ш. Цахар гэвш хэмээн алдаршсан нэрт эмч Лувсанчүлтэм (1740— 1810) нь ХП машинд гарсны цагаан бичин жил төржээ. Тэр 7 настайгаасаа эхлэн монгол бичиг сурахын хамтаар төвд бичиг сурч улмаар анагаах ухааныг сонирхон судалж мөн гүн ухаан, зурхай, яруу найраг зэрэг олон талын мэдлэг эзэмшжээ. Түүний зохиосон «Эм таних ухаан Ман-о-шижид» хэмээх зохиол нь 60x12 см-ийн хэмжээтэй 78 хуудас, 6 мөрлөн, хар бэхээр хэвлэсэн модон барын судар юм. Лувсанчүлтэм энэ томоохон бүтээлдээ нийт 678 эмийн зүйлсийг эрдэнийн эм, шороон эм, өвсөн эм, давсан эм гэх мэт 10 хэсэгт хувааж бодис тус бүрийн хэлбэр дүрс, ургах орчныг онцгойлон тайлбарласнаас гадна амт, чадал, яс чанар, төрөл зүйл зэргийг тодорхой бичсэн болой. Үүнээс гадна «Судас шинжлэх товч хураангуй Задагчүлдордуй» хэмээх зохиолдоо судас барих хэмжээ, судасны өвөрмөц ба төрөлхийн зан чанар зэргийг хэд хэдэн хэсэгт хувааж тодорхой бичсэн нь сонирхолтой бүтээл болжээ. Лувсанчүлтэмийн бүрэн зохиол нь «Цахар гэвшийн сүмбум» хэмээн алдаршсан бөгөөд анагаах ухаан, гүн ухаан, яруу найраг, зур хайн сэдвээр 10 боть бүтээл туурвисан юм.

IV. Миндол Номон хаан хэмээн алдаршсан эмч Жамбал нь ХШ машид гарсны, шарагчин тахиа жил буюу 1789 онд Донровсайдангийн гэрт мэндэлсэн. Бүтэн нэрийг нь Жамбалчойжи-данзанпэрэнлэй гэдэг. Тэр багаасаа эхлэн төвд бичиг болон анагаах ухаан, бүддийн гүн ухаанд суралцан эзэмшээд монгол, төвдийн олон газраар явж, амьдралынхаа ихэнх хугацааг анагаах ухаанд зориулж гарамгай амжилт гаргасан байна. Тухайлбал: 1829 оны үед «Увидасын далай-Ман агринчэн-жунай» хэмээх алдарт зохиолоо төвд хэлээр бичжээ. Энэ бүтээл нь монгол эмийн найрлагын нэгэн бүрэн бүтэн сонгодог зохиол болно. Тус зохиолд 200 гаруй эмийн найрлагыг нийт 76 бүлэгт багтааж дэлгэрэнгүй бичсэн байна. Мөн өвчин үүсэх шалтгаан, шинж чанар, төрөл зүйл, засах арга зэргийг тодорхой өгүүлжээ. Хожим нь Жамбалзундуй гэдэг анагаах ухаантан энэ зохиолыг тайлбарлаж «Хувилгаан түлхүүр-Пүрэлжи дэмиг», «Эрдэнийн түлхүүр-Ринчэн дэмиг», «Далд утгын түлхүүр-Санва дэмиг», «Оньсон түлхүүр-Наджи дэмиг» хэмээх 4 дэвтэр тайлбар зохиол бичжээ. Товчоор «Увидасын далайн 4 түлхүүр» гэдэг. Үүний гол агуулга нь нууц нэр томъёог тайлбарласан ажээ.

V. XIX зууны үе дэх алдарт эмч Ишданзанванжил нь XIV машид гарсны харагчин үхэр жил буюу 1853 онд Жамбалдоржийн гэрт төржээ. Тэр бага наснаасаа хурц ухаантай сэргэлэн хүүхэд байсан бөгөөд төвд бичиг болон анагаах ухаанд шамдан суралцжээ. 20 настайдаа Андуугийн Гүмбум хийдэд очиж Буддийн гүн ухаан, анагаах ухаанд суралцаад системтэй онолын мэдлэгийг эзэмшсэн байна. Ишданзанванжилын төвд хэлээр зохиосон «Шүрэн чимэгжүрүдошал», «Эрдэнэчимэг-Ринчэндошал», «Сувдан чимэг-Мүдэгдашил» зэрэг 3 дэвтэр байх бөгөөд монгол хэлээр зохиосон «Эмнэлгийн шүлэг — 154 байдаг» гэсэн нэгэн дэвтэр зэрэг нийт 4 дэвтэр анагаах ухааны зохиол бичсэн нь тодорхой байна.

VI. Монгол орон даяар Лүнриг Дандар буюу онолын ухаантан хэмээн алдаршсан энэ хүн 1835 онд хуучин Далай чойнхор вангийн нутагт төржээ. Бага наснаасаа эмнэлгийн сургуульд суралцаж, анагаах ухааныг ихэд сонирхон сурч судлаад «Маарамбын дамжаа» амжилттай барьж, маарамба хэмээх цол хамгаалсан байна. Лүнриг Ландарын зохиосон анагаах ухааны зохиол нь нийт 4—5 боть бөгөөд Далай вангийн хошуунд төвд хэлээр модон бараар хэвлэгджээ. Үүнд: «Анагаах ухааны 4 үндсийн тайлбар-Жүд Ши дадал» хэмээх судар нь 40x10 см-ийн хэмжээтэй, 156 бүлэгтэй, 870 хуудас бүрэн бүтэн томоохон бүтээл юм. Энэ нь «Анагаах ухааны 4 үндэс» судрын бүх бүлгийг алгасалгүй нарийн шинжлэн судлаад ихээхэн шүүмжлэлтэй хандаж олон зүйлийн алдаа эндүүрлийг онолын үүднээс засамжлан залруулж тайлбарласан ажээ. Зохиогч «...Би өөрийн монгол оронд ургадаг эмийн түүхий эдийг зөв таньж мэдэхийн эрхээр бичсэн бөгөөд урьдах онол, ёс лугаа үл зохилдох олон зүйл гарах тул бүү эргэлзээрэй» хэмээн онцлон тэмдэглэсэн байна. Иймээс эмийн зүйлсийг өөрийн монгол оронд ургадаг хэлбэр дүрсээр нь ойлгомжтой энгийн хэллэгээр тайлбарласан нь түүний оюуны өргөн мэдлэгийг тодорхой илтгэж байна.

«Жүд-ши-тажод» хэмээх бүтээл нь 52x11 см-ийн хэмжээтэй 312 гаруй хуудастай бөгөөд бүрэн барлагдаж амжаагүй модон барын судар билээ. Энэ нь анх удаа монгол эмч анагаах ухааны бүх асуудлуудыг тухайн үеийн гүн ухаантай нягт уялдуулж асуулт, хариултын хэлбэрээр нарийн нягт шинжлэн судалж тайлбарласан нь судалгааны

чухал ач холбогдолтой бөгөөд эрдэмтдийн анхаарлыг ихэд татаж байна.

«Анагаах ухааны түүх-Манжи-Чойжүн» хэмээх 40х 10 см-ийн хэмжээтэй, 300 гаруй хуудас, гар бичмэл, ганц хувь хадгалагдан үлдсэн нэн ховор нандин энэ бүтээл нь Энэтхэг, Төвд, Монголын анагаах ухааны нэрт төлөөлөгчид болон тэдгээрийн зохиол бүтээлүүдийн талаар тодорхой бичсэн байна.⁶ Жишээ нь: Эртний Энэтхэгийн Аюурвед (насны ухаан) их хөлгөн сударт гардаг мэс заслын зан үйл, өвчнийг гаднах шинжээр танин мэдэх арга, тосон эм болон элсээр жин тавих зэрэг эмгүй эмчилгээний аргуудыг дурьджээ. Мөн манай он тооллын П зууны үед гүн ухаан, зурхай, анагаах ухаан, түмэн бодисын ухаанд гарамгай мэргэжсэн эрдэмтэн Нагаржунай, Кашмирын алдарт эмч Багвахата (төвдөөр Ловон Баву) зэрэг олон алдар цуутай хүмүүсийн зохиол бүтээл болон Төвдөд соёлын талаар сэргэн мандалтын үе болсон VII—IX зуун буюу түүнээс хойшхи үеийн эмч нарын бүтээсэн эмийн ном судрын талаар дэлгэрэнгүй гаргасан байна. . Эмийн 4 үндэс судар нь Энэтхэг, Төвдийн оронд дэлгэрээд Их Чингис хааны байгуулсан монгол улсад дэлгэрсэн нь хэмээн монгол эмнэлэг хөгжсөн түүхийг өгүүлжээ.⁷ Иймээс дорнодахины анагаах ухааны түүхийн холбогдолтой энэ ном нь эрдэм шинжилгээний ажилтан анагаах ухааны түүх судлаачид, эмч нарын анхаарлыг зүй ёсоор татах учиртай.

«Лхантавын тайлбар» хэмээх бүтээл нь 40х 10 см-ийн хэмжээтэй 200 гаруй хуудас модон барын бүрэн хэвлэл ажгуу. Гол агуулга нь Лхантав гэдэг эмчилгээний зохиол доторхи ёгт нэр, гүн далд утгатай үг хэллэг бүрийг чадамгай тайлбарлаж чадсанд оршино.

«Халуун хүйтний судлал-Цаадан галдон таажод» хэмээх судар нь 38х10 см-ийн хэмжээтэй, 30 гаруй хуудас гар бичмэл юм. Үүнд халуун хүйтний онолын талаархи асуудлуудыг гол болгон тайлбарласан байна. Цаашилбал XIX зууны үед алдарт монгол эмч Жамбал дорж «Үзэсгэлэнт нүдний чимэг-Зэйцармигжан» хэмээх зохиол төвд хэлээр зохиожээ. Тус ном бол монгол эм судлалын тухай нэгэн боть бүрэн бүтэн системтэй, сонгодог зохиол болно. Үүнд: 879 зүйлийн эмт бодисыг 8 аймаг, 24 төрөлд хувааж, эмийн бодис (ургамал) нэг бүрийн монгол, төвд, манж, хятад нэр болон ургах газар орон, хэлбэр дүрс, амт чанар чадал, эмэнд орох хэсэг, түүж авах цаг хугацаа, боловсруулах арга зэргийг нарийн тодорхой тайлбарлаж 576 зураг хавсаргасан байна. Үүнээс гадна мэс заслын багаж, ханах, төөнөх, хатгах эмчилгээ хийх цэгүүдийг зургаар тайлбарлажээ.⁸ Мөн түүнчлэн эмч Ёндонгийн зохиосон «Төвд, монгол эмнэлгийн толь бичиг-Балдан жүд-ши-шинрайсалва мэлон», эмч Чойнпилийн «Энэрэнгийн хураангуй-Жэдүйнинн-ор», эмч Жигмэдданзанжамцын «Үзэгчдийн баясгалан Тонва гажид» зэрэг эмчилгээний томоохон алдарт бүтээлүүдээс гадна зохиогч болон он жил нь тодорхой бус зохиол бүтээл олноороо олдож байна. Жишээ нь: «Домын судар», «Элдэв зүйлийн эмийн найрлага», «Судас барих судар», «Зурхай ба анагаах ухаан» гэх мэт.

1. Монгол Данжуур. 102-р боть. УННС-ийн монгол фонд
2. «Рашаан зүрх найман гишүүнт нууц увидасын үндэс» монгол модон барын хэвлэл» Минжүүр Цоржийн орчуулга (XVШ зууны) АЭХ-ийн номын сан
3. Лувсанданзанжанцан (1639----1704)

Эцэст нь дүгнэж хэлэхэд XVI—XX зууны эхэн үе хүртэлх 400 гаруй жилийн түүхэн хугацаанд онол ба эмчилгээний баялаг туршлагатай, өвөрмөц онцлогтой монгол анагаах ухааны олон ном, судрыг эмч, оточ нар маань голдуу төвд хэлээр зохиож өөрийн гэсэн өнгө аяс арга барилтай монгол эмнэлгийг хөгжүүлж байжээ.

— rtza-rgyudkyi 'grel-ba gsal-ba'i sgron-me

-- Ханчэн чойжал Лувсанданзанжанцангийн сүмбумын "Nga" буюу IV. боть, ламын гэгээний барын хэвлэл, хуудас 26, АЭХ-ийн номын сан

4. Ишбалжир (1704—1788) bdud-rtzi thig-ba Бээжин барын хэвлэл, хуудас 27б, -УННС-ийн төв фонд

5. Ишбалжир -bdud-rtzi shil-dkar. Бээжин барын хэвлэл, хуудас 32б, УННС-ийн төв фонд

6. Лүнриг Дандар (1835—1915) sman gyi rgyud-bzhi'i brda dan don ga' zhig bkrol-ba nam rgyal arura'i 'phreng-ba'i mdzes rgyan zes bya ba bzhugs so. Далай вангийн барын хэвлэл, хуудас 93а. АЭХ-ийн номын сан

7. Лүнриг Дандар-sman gyi choi 'byung gar бичмэл, хуудас 151. АЭХ-ийн номын сан

8. Жамбалдорж (XIX зуун) gso byed bdud-rtzi" i "khrul' med bgos-'zhin bzo rig me-long du rnam-par shar-ра mdzes mtsar mig rgyan zes bya-ba bzhugs so. Бээжин барын хэвлэл, хуудас 156. АЭХ-ийн номын сан

9. Б. Жигмэд: «Монгол анагаах ухааны товч түүх» Хөх хот. 1985, 161—204-тал